

“БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК

БАТЛАВ “ББЭХС” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.НЯМТУУЛ



**АЛБАНЫ ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛЖ КОМПЬЮТЕР
ТҮҮНИЙ ДАГАЛДАХ ТЕХНИК ХЭРЭГСЭЛ
ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН ҮНИЙН
САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: Албаны хэрэгцээнд зориулж компьютер түүний дагалдах техник хэрэгсэл худалдан авах

Төслийн дугаар: ББЭХС/202001023

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Албаны хэрэгцээнд зориулж компьютер түүний дагалдах техник хэрэгсэл худалдан авах** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 15⁰⁰ цагаас өмнө цахимаар** ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 15³⁰ цагт** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй

Тендерийн хамт 600,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Увс аймаг, Улаангом сум 10 баг “Баруун бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК, 2 давхар Хууль эрх зүй, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
Б.Одгэрэл, 99042951, 70453385**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |

6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>Ашигтай ажилласан жилийн тоо 1 жил</p> <p>Гүйцэтгэгчээр ажилласан жилийн тоо 1 жил</p> <p>Борлуулалтын орлого 20 саяас дээш</p> <p>Тендерийн баталгаа 600,000 төгрөг</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Увс аймаг, Улаангом сум, 10 баг “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2 давхар</p> <p>Огноо: 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр</p> <p>Цаг: 15 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Увс аймаг, Улаангом сум, 10 баг “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2 давхар</p> <p>Огноо: 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр</p> <p>Цаг: 15 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 2. Татварын газрын тодорхойлолт 3. ШШГГ-ын тодоройлолт 4. Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан

	<p>5. Ашигтай ажилласан жилийн тоо 1 жил</p> <p>6. Гүйцэтгэгчээр ажилласан жилийн тоо 1 жил</p> <p>7. Борлуулалтын орлого 20 саяас дээш</p> <p>8. Тендерийн баталгаа 600,000 төгрөг</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Олон үйлдэлт хар, цагаан хувилагч төхөөрөмж 1 ком, ширээний компьютер 8 ком, зөөврийн компьютер 3 комыг нийлүүлэх.
2. **Стандарт:** Суурин компьютер, зөөврийн компьютерийн үзүүлэлт

№	Нэр төрөл	Барааны техник тодорхойлолт, үзүүлэлт, шаардлага	Тоо/хэмжээ
1	Суурин компьютер	Processor Dell Optiplex 3070MT i3 түүнтэй дүйцэхүйц -Процессор: Intel Core i3 (only - 9th Gen) Cores/9MB/6T/3.0GHz to 4.4GHz/65W) -Үйлдлийн систем: Windows 10 -Санах ой: 8GB, 2400MHz, DDR4 Memory -Хатуу диск: 3.5 inch, 1TB, 7200rpm -График карт: Intel UHD Graphics 630 -DVD оролт: Тийм -Оролтууд: 8 External USB Type-A: 4 x 3.1 (2 front/2 rear) and 4 x 2.0 (2 front/2 rear), 2 Internal USB 2.0, 1 RJ-45, 1 DisplayPort 1.2, 1 HDMI 1.4, 1 UAJ, 1 Line-out	8
2	Компьютерийн дэлгэц	Monitor Dell E2016H түүнтэй дүйцэхүйц -Хэмжээ: 19,5 inches -Гэрлийн технологи: Wide FHD LED -Нягтрал: 1600 x 900 at 60 Hz -Холболт: Display port, VGA	8
3	Компьютер	Notebook Dell Inspiron 3593 i5-1065G7 түүнтэй дүйцэхүйц -Процессор: 10th gen Intel® Core™ i5 -Дэлгэцийн хэмжээ: 15,6” -Үйлдлийн систем: Windows 10 -Санах ой: 8GB, 1x8GB, DDR4, 2666MHz -Хатуу диск: 1TB 5400 rpm -График карт: NVIDIA® GeForce® MX230 with 2GB GDDR5 graphics memory -Оролтууд: SD Card Reader 2. USB 2.0 3. Wedge-Shaped Lock Slot 4. Power 5. USB 3.1 Gen 1 Type-C™ 6. HDMI 1.4b 7. RJ45 8. (2) USB 3.1 Gen 1 9. Headphone & Microphone Audio Jack	3

Тусгай нөхцөл:

- Баталгаат хугацаа 1 жил

Хар цагаан олон үйлдэлт хувилагчид тадигдах шаардлага:

Konica Minolta Bizhub 225i түүнтэй дүйцэхүйц

Үндсэн функц: *Хэвлэх, хувилах, скайнердах, бүрэн автомат, А3 – А5, хоёр талд хэвлэх automating duplexing*

Хэвлэх, хувилах хурд /1мин/: 22 хуудас,

2 талдаа хэвлэх хурд: Тийм (1 мин 15.8 хуудас)

Үндсэн хэвлэх эхийн хэмжээ: А3-А5

Нягтрал: Print 1200x600 dpi, Read 600x600 dpi, Copy 600x600 dpi

Сүлжээний холболт: 10/10 BASE-T, USB2.0 (Hi-Speed)

Санах ой: 256 МВ

Цаасны жин: 64 – 157гр

Цаасны эхийн хэмжээ: 25% - 400% (in 0.1% increments)

Дэмжих үйлдлийн систем: Linux, Ubuntu, Windows

СКАННЕР

Хурд: /1мин/: 55 хуудас,

Боломж: Scan to TWAIN scan, Scan to PC, Scan to USB, Scan to FTP, Scan to E-mail

Өнгөт скайнер: Тийм

Скайнерын нягтаршил: 600x600 dpi equiv, 400x400 dpi,

300x300 dpi, 200x200 dpi

Формат: PDF, JPEG, TIFF, Linearised PDF, XPS

ХУВИЛАХ

Ажилд бэлэн болох хугацаа: 15 сек – ээс бага

Эхний хуудас гарах хугацаа: 6,5 сек – ээс бага

Нягтаршил: 600 x 600 dpi

2 талдаа хэвлэх/хувилах боломж /Duplex/: Тийм

Бүүклэт буву ном тохимолон хэвлэлт хийх боломжтой эсэх: Тийм

Нэг ажлаар хийх хэмжээ: 1 – 999 хувь

Цаасны дээд хэмжээ: А3, В4, А4, В5

Цаасны жин: 64 – 157гр

Цаасны багтаамж: Стандарт - 350 хуудас,

Эзэлхүүн: 607*570*458 mm

Жин: 28,2кг

Тэжээл: 220–240 V / 50/60 Hz

Тэжээлийн залгуур: Европ стандарт

Чадал: 1.30 kW

АВТОМАТ ЦААС ТАТАГЧ ТАГ

130-с доошгүй цаас багтдаг байх

Ар, өвөргүй хэвэлдэг татдаг байх

СУУРЬ

Цаас агуулах бүхий зориулалтын тэнцвэржүүлэгч төмөр суурьтай байх

ХОР, БУЛ

Бул:

- *Хар К: 55.000 хуудсаас доошгүй хэвэлдэг байх*

Хор:

- *Хар К: 12,000 хуудсаас доошгүй хэвэлдэг байх*

Тусгай нөхцөл:

- Засвар үйлчилгээний төвтэй байх
- Оригинал хор бул, сэлбэг хэрэгслээр хангах
- Дуудлага өгсөн тохиолдол түргэн шуурхай утсаар зөвөлгөө өгдөг байх, алсын зайнаас тохиргоо хийдэг байх
- Баталгаат хугацаа 1 жил
- Англи, Монгол хэл дээр заавартай байх

3. **Бараа хүргэх газар:** Увс аймаг, Улаангом сум, 10 баг “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК

4. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
“ББЭХС” ТӨХК	Албаны хэрэгцээнд зориулж компьютер түүний дагалдах техник хэрэгсэл худалдан авах	Техникийн тодорхойлолтын дагуу	ширхэг	ББЭХС ТӨХК-ийн байр	Гэрээнд заасны дагуу	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	-

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:

1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааг хүргэсэн тухай баримт
3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага:

Баталгаат хугацаа 1 жил |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн 100% хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9) ¹ | 9.1. Алданги оногдуулах хувь: 0.3%

Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн 10% хэтрэхгүй |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ___ дугаар сарын ____-наас _____ оны ___ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.